



**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН  
ХОРШООДЫН  
2023 ОНЫ 1 ДҮГЭЭР  
УЛИРЛЫН САНХҮҮГИЙН  
ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН  
ТАНИЛЦУУЛГА**

**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ГАЗАР**

**УЛААНБААТАР ХОТ**

# АГУУЛГА

<b>НЭГ.САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ</b> .....	2
1.1 Зах зээлийн ерөнхий мэдээлэл.....	2
1.2 ХЗХ-дын тархалтын мэдээлэл.....	3
1.3 ХЗХ-дын гишүүдийн мэдээлэл.....	3
1.4 Бодлого, зохицуулалтын орчин.....	5
<b>ХОЁР.НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД</b> .....	6
2.1 Статистик үзүүлэлтүүд.....	6
2.2 Санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд.....	9
2.2.1 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд.....	9
2.2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд.....	10
<b>ГУРАВ.НИЙТ ХӨРӨНГИЙН БҮТЭЦ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА</b> .....	11
3.1 Хөрөнгийн бүтцийн талаар.....	11
3.2 Хөрөнгийн төвлөрлийн талаар.....	12
3.3 Зээлийн үйл ажиллагааны талаар.....	12
3.4 Зээлийн чанарын талаар.....	13
<b>ДӨРӨВ.НИЙТ ЭХ ҮҮСВЭРИЙН БҮТЭЦ, ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА</b> .....	15
4.1 Эх үүсвэрийн бүтцийн талаар.....	15
4.2 Хадгаламжийн үйл ажиллагааны талаар.....	16
4.3 Бусдаас авсан зээл, өр төлбөрийн талаар.....	17
4.4 Бусад богино хугацаат өр төлбөрийн талаар.....	17
4.5 Гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн талаар.....	18
4.6 Өөрийн хөрөнгө, хоршоологчдын өмчийн талаар.....	18
<b>ТАВ.ОРЛОГО, ЗАРДАЛ, АШИГТ АЖИЛЛАГАА</b> .....	19
5.1 ХЗХ-дын орлогын талаар.....	19
5.2 ХЗХ-дын зардлын талаар.....	19
5.3 ХЗХ-дын ашигт ажиллагааны талаар.....	20
<b>ЗУРГАА.ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ</b> .....	20
6.1 ХЗХ-дын шалгуур үзүүлэлтийн талаар.....	20
<b>ДОЛОО.ДҮГНЭЛТ</b> .....	21

# ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН 2023 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2023.05.08


Улаанбаатар хот

## НЭГ. САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

### 1.1 Зах зээлийн ерөнхий мэдээлэл

2023 оны 1 дүгээр улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-оос хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон 191 хадгаламж, зээлийн хоршоо (цаашид “ХЗХ” гэх) үйл ажиллагаа явуулж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14 ХЗХ буюу 6.8 хувиар буурсан үзүүлэлт юм. Тайлант улиралд нийт ХЗХ-дын 47.1 хувь буюу 90 ХЗХ орон нутагт, 52.9 хувь буюу 101 ХЗХ Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байна.

График 1: ХЗХ-дын тоо /хот, орон нутгаар/



ХЗХ-дын тоо сүүлийн 5 жилийн хугацаанд тасралтгүй буурсан боловч санхүүгийн болон статистик үзүүлэлтүүд харьцангуй тогтвортой байгаа нь зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг 4 улирал дараалан

хангаагүй, өөрийн хөрөнгөгүй болсон, хоршоологчдын өмчгүй болж үйл ажиллагаа нь доголдсон ХЗХ-дын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбоотой.

Тайлант улиралд Хорооны хуралдаанаар 1 ХЗХ-нд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, 1 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, 6 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлыг шийдвэрлэсэн байна. Мөн 3 ХЗХ-ны 12 сонгуульт гишүүн, 2 ХЗХ-ны ажлын байрны хаягийн өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүртгэсэн байна.

Хүснэгт 1: ХЗХ-дын тусгай зөвшөөрлийн мэдээлэл

Он	2019	2020	2021	2022	2023.1
ХЗХ-дын тоо	261	249	209	196	191
Шинээр олгосон	17	14	-	7	1
Хүчингүй болгосон	35	26	40	20	6
Түдгэлзүүлсэн	10	23	12	13	1
Сэргээсэн	1	6	1	3	-
ТЗ-ийн хугацаа сунгасан	52	49	85	62	-*

\*ХЗХ-ны тухай хуульд 2023.01.06-ны өдөр орсон өөрчлөлтийн дагуу ХЗХ-ны тусгай зөвшөөрөл хугацаагүй болсон.

## 1.2 ХЗХ-дын тархалтын мэдээлэл

2023 оны 1 дүгээр улирлын байдлаар 191 ХЗХ 61 салбар, 685 ажилтан, 69,962 гишүүн /69,721 иргэн, 241 хуулийн этгээд/-тэйгээр Монгол Улсын 21 аймаг, нийслэлийн 8 дүүрэгт үйл ажиллагаа явуулж байна.

Улаанбаатар хотын 8 дүүрэгт 101 ХЗХ үйл ажиллагаа явуулж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13 ХЗХ буюу 11.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүдэд хамгийн их төвлөрөлтэй байна.

Орон нутагт Сэлэнгэ аймгаас бусад 20 аймагт 90 ХЗХ үйл ажиллагаа явуулж байна. Баян-Өлгий, Увс, Говь-Алтай, Ховд, Дорнод аймгуудад төвлөрөл их байгаа бол Булган, Говьсүмбэр, Өвөрхангай, Сүхбаатар, Хэнтий аймагт тус бүр 1 ХЗХ үйл ажиллагаа эрхэлж байна.

Зураг 2: ХЗХ-дын тархалт



Салбарын тархалтын хувьд 3 ХЗХ-ны 4 салбар Улаанбаатар хотод, 5 ХЗХ-ны 57 салбар орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

## 1.3 ХЗХ-дын гишүүдийн мэдээлэл

2023 оны 1 дүгээр улирлын байдлаар ХЗХ-дын нийт гишүүдийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5,004 гишүүн буюу 6.7 хувиар буурч 69,962-т хүрсэн үзүүлэлттэй байна. Нийт гишүүдийн 0.3 хувь буюу 241 нь хуулийн этгээд, 54.6 хувь буюу 38,202 нь эмэгтэй гишүүд байна.

Зураг 1: Улаанбаатар хотын ХЗХ-дын тархалт




Зураг 3: ХЗХ-ны гишүүдийн мэдээлэл



Нийт гишүүдийн 54.8 хувь буюу 38,326 гишүүн Улаанбаатар хотын ХЗХ-нд бүртгэлтэй бол 45.2 хувь буюу 31,636 гишүүн орон нутгийн ХЗХ-нд бүртгэлтэй байна.

График 2: ХЗХ-дын тоо болон гишүүдийн өөрчлөлт /хот, орон нутгаар/



Сүүлийн 5 жилийн хугацаанд ХЗХ-дын тоо буурсан ч 2019-2021 оны 1 дүгээр улирлын байдлаар гишүүдийн тоо тогтмол өсч байсан бол тайлант хугацаанд 6.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлдэг ХЗХ-дын гишүүдийн 13.3 хувь буюу 5,084 гишүүн “Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр”-ийн хүрээнд байгуулагдсан 44 ХЗХ-ны гишүүд байна.

Мөн тайлант улиралд “Ногоон алт малын эрүүл мэнд төсөл”-ийн санхүүжилттэй 29 ХЗХ 10,570 гишүүнтэй үйл ажиллагаа явуулсан байна.


Нийт 191 ХЗХ-ны 32.5 хувь буюу 62 ХЗХ 20-100 гишүүнтэй, 51.8 хувь буюу 99 ХЗХ 101-500 гишүүнтэй, 9.4 хувь буюу 18 ХЗХ 501-1,000 гишүүнтэй, 6.3 хувь буюу 12 ХЗХ 1,001-ээс дээш гишүүнтэй байна.

Хүснэгт 2: ХЗХ-ны гишүүнчлэл, интервалаар

Гишүүд /интервалаар/	ХЗХ-ны тоо	Гишүүдийн тоо	Нийт гишүүдэд эзлэх хувь
20-100 гишүүнтэй	62	3,399	4.8%
101-500 гишүүнтэй	99	21,111	30.2%
501-1,000 гишүүнтэй	18	12,150	17.4%
1,001-ээс дээш гишүүнтэй	12	33,302	47.6%
<b>Нийт</b>	<b>191</b>	<b>69,962</b>	<b>100.0%</b>

Гишүүдийн төвлөрлийг хүснэгтээр харуулбал 1,001-ээс дээш гишүүнтэй 12 ХЗХ-ны гишүүд нийт гишүүдийн 47.6 хувийг эзэлж байна.

График 3: ХЗХ-ны гишүүдийн төвлөрөл



## 1.4 Бодлого, зохицуулалтын орчин

### Гадаад харилцаа, хамтын ажиллагаа

- Хадгаламж, зээлийн хоршооны чиглэлээр туршлага солилцож хамтран ажиллах тухай хүсэлтийг Койкагийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газарт 2023 оны 3 дугаар сарын 02-ны өдөр хүргүүлсэн. Тус газраас салбарын чиглэлээр зөвлөх ажиллуулах болон сургалтын чиглэлээр хамтарч ажиллах боломжтой талаар хариуг ирүүлээд байна.

### Хууль, эрх зүйн орчин

- “Хадгаламж, зээлийн хоршооны ёс зүйн дүрмийн үлгэрчилсэн загвар”-ыг Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2023 оны 02 дугаар тушаалаар баталсан. Үлгэрчилсэн загварт хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд мөрдөх ёс зүйн нийтлэг хэм хэмжээ, хоршооны гишүүн, тэргүүлэгчдийн зөвлөл, хяналтын зөвлөл, зээлийн хорооны гишүүн болон гүйцэтгэх захирал, ажилтны үйл ажиллагаандаа баримтлах зарчим, ёс зүйн хэм хэмжээг тогтоохоос гадна үлгэрчилсэн загварыг мөрдүүлэх, хэвшүүлэхтэй холбоотой шаардлагыг мөн тодорхойлсон.
- “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт”-ийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж олон нийт болон зах зээлийн оролцогчдоос санал авахаар Хорооны цахим хуудаст 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр байршуулсан.
- Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоо хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийн 2022 оны хэрэгжилтийг нэгтгэн дүгнэж, цаашид

хамтран авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг гаргасан.

- Сангийн яамны төрийн нарийн бичгийн даргын 2022 оны А/156 тоот тушаалаар байгуулсан “Хадгаламж, зээлийн хоршооны нягтлан бодох бүртгэлийн журмыг шинэчлэн батлах” ажлын хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны төлөөлөл ажиллаж, ажлын хэсгээс “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн заавар, дансны нэгдсэн жагсаалт, санхүүгийн тайлангийн маягт, тодруулга бэлтгэх аргачлал”-ын шинэчилсэн найруулгын төслийг бэлтгэсэн бөгөөд Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн батлуулахаар 2023 оны 3 дугаар сарын 29-ний өдөр Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн газарт хүргүүлсэн.
- Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2022 оны 498 дугаар тушаалаар холбогдох дүрэм, журам, заавар зэргийг боловсруулах, судалгаа шинжилгээ хийх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан бөгөөд 3 дэд ажлын хэсэгт хуваагдан ажилласан. Ажлын хэсгийн боловсруулсан “Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн бүртгэл, үйл ажиллагааны журам”, “Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бүртгэлийн дэвтэр хөтлөх, тайлан мэдээ ирүүлэх журам”, “Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хувийн дугаар олгох журам”, “Мөнгөн зээлийн үйл ажиллагааны сургалтын журам”, “Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлийн ажиллах журам”-ын төслийг Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 81, 82, 83, 84, 85 дугаар тогтоолоор тус тус баталж, 2023 оны 3 дугаар сарын

23-ны өдөр Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн.

- Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэнтэй холбогдуулан УИХ-аас 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр баталсан Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаарх мэдээллийг нийт хадгаламж, зээлийн хоршоодод хүргүүлсэн.
- “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журам”-ын төслийг боловсруулсан ба журмын хавсралт болох “Зайнаас эрдэлийн үнэлгээ хийх аргачлал”-ын төслийн онооны системийг туршиж нэр бүхий 49 ХЗХ-нд зайны үнэлгээ

хийсэн. Зайны үнэлгээний дүнд үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2023 оны 184 дүгээр тушаалаар баталсан удирдамжийн дагуу дээрх журмын төслийн хоёрдугаар хавсралт болох “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд газар дээрх хяналт шалгалт хийх заавар”-т ажлын хэсгийн гишүүд туршилт хийж байна.

### Хурал, семинар, уулзалт

- Бичил санхүүгийн бодлогын зөвлөлийн ээлжит хурлыг 2023 оны 3 дугаар сарын 03-ны өдөр хуралдуулж Монголбанкнаас Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэхээр төлөвлөсөн зөвлөмжийн төсөл болон бичил санхүүгийн салбарын цаг үеийн нөхцөл байдал, хууль тогтоомжийн биелэлтийн талаар зөвлөлийн гишүүдтэй санал солилцсон.

## ХОЁР. НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тусгай зөвшөөрөлтэй 191 ХЗХ-оос 2023 оны 1 дүгээр улирлын тайлангийн нэгтгэлд 6 ХЗХ өмнөх улирлын тайлангаар хамрагдсан.

### 2.1 Статистик үзүүлэлтүүд

Хүснэгт 3: ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Статистик мэдээлэл	ХЗХ-ны нийт гишүүд		Үүнээс:			
			Улаанбаатар хот		Орон нутаг	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
<b>ХЗХ-дын тоо</b>	<b>191</b>	<b>100.0%</b>	<b>101</b>	<b>52.9%</b>	<b>90</b>	<b>47.1%</b>
<b>Нийт гишүүдийн тоо</b>	<b>69,962</b>	<b>100.0%</b>	<b>38,326</b>	<b>54.8%</b>	<b>31,636</b>	<b>45.2%</b>
Эрэгтэй	31,519	45.1%	16,074	51.0%	15,445	49.0%
Эмэгтэй	38,202	54.6%	22,079	57.8%	16,123	42.2%
Гишүүн хуулийн этгээд	241	0.3%	173	71.8%	68	28.2%
<b>Гишүүдийн насжилт</b>	<b>69,721</b>	<b>100.0%</b>	<b>38,153</b>	<b>54.7%</b>	<b>31,568</b>	<b>45.3%</b>
18-35 насны	19,047	27.3%	10,787	56.6%	8,260	43.4%
36-45 насны	20,680	29.7%	11,756	56.8%	8,924	43.2%
46-55 насны	16,929	24.3%	8,576	50.7%	8,353	49.3%
55-аас дээш	13,065	18.7%	7,034	53.8%	6,031	46.2%
<b>Гишүүдийн боловсрол</b>	<b>69,721</b>	<b>100.0%</b>	<b>38,153</b>	<b>54.7%</b>	<b>31,568</b>	<b>45.3%</b>
Дээд	31,055	44.5%	21,241	68.4%	9,814	31.6%
Тусгай дунд	11,660	16.7%	7,116	61.0%	4,544	39.0%
Бүрэн дунд	16,966	24.3%	8,473	49.9%	8,493	50.1%
Дунд	7,064	10.1%	1,153	16.3%	5,911	83.7%
Бага	2,976	4.4%	170	5.7%	2,806	94.3%
<b>Нийт ажилтнуудын тоо</b>	<b>685</b>	<b>100.0%</b>	<b>399</b>	<b>58.2%</b>	<b>286</b>	<b>41.8%</b>
Үүнээс: эмэгтэй	475	69.3%	279	58.7%	196	41.3%
<b>Санхүүгийн програмтай</b>	<b>99</b>	<b>51.8%</b>	<b>41</b>	<b>41.4%</b>	<b>58</b>	<b>58.6%</b>
Монголбанкны СМА-нд 20 сая төгрөгөөс дээш бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлсэн ХЗХ-дын тоо	15	100.0%	11	73.3%	4	26.7%

Гүйлгээний тоо	101	100.0%	52	51.5%	49	48.5%
Гүйлгээний дүн /мян.төг/	14,988,367.20	100.0%	3,594,836.99	24.0%	11,393,530.21	76.0%
<b>Монголбанкны СМА-нд сэжигтэй гүйлгээг мэдээлсэн ХЗХ-дын тоо</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
Сэжигтэй гүйлгээний тоо	0	0	0	0	0	0
Сэжигтэй гүйлгээний дүн /мян.төг/	0	0	0	0	0	0

2023 оны 1 дүгээр улиралд нийт ХЗХ-дын 7.9 хувь буюу 15 ХЗХ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7.1-д заасны дагуу Монголбанкны СМА-нд 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний нийт 14,988,367.20 мянган төгрөгийн 101 гүйлгээг мэдээлсэн байна. Дээрх гүйлгээний дүнгийн 24.0 хувь буюу 3,594,836.99 мянган төгрөгийн 52 гүйлгээг Улаанбаатар хотын 11 ХЗХ, 76.0 хувь буюу 11,393,530.21 мянган төгрөг бүхий 49 гүйлгээг орон нутгийн 4 ХЗХ мэдээлсэн байна. Тайлант улирлын байдлаар сэжигтэй гүйлгээ гараагүй байна.

ХЗХ-дын нийт гишүүдийн 57.0 хувийг 18-45 насныхан эзэлж байна. Гишүүдийн насжилтыг хот, орон нутгаар харьцуулахад Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүдийн насжилт орон нутгийн ХЗХ-дын гишүүдээс харьцангуй залуу байна.

Нийт гишүүдийн 44.5 хувь нь дээд боловсрол эзэмшсэн байна. Гишүүдийн боловсролын түвшинг хот, орон нутгаар

харьцуулахад Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүдийн боловсролын түвшин орон нутгийн ХЗХ-дын гишүүдээс өндөр буюу дээд боловсролтой нийт гишүүдийн 68.4 хувь нь Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүд байна.

График 4: ХЗХ-ны гишүүдийн насжилт, УБ, орон нутгаар





График 5: ХЗХ-дын гишүүдийн боловсролын түвшин, УБ, орон нутгаар



Хүснэгт 4: ХЗХ-дын зээлдэгчдийн статистик үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Статистик мэдээлэл	ХЗХ-дын нийт зээлдэгч		Үүнээс:			
	Тоо	Хувь	Улаанбаатар хот		Орон нутаг	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
<b>ХЗХ-дын тоо</b>	<b>191</b>	<b>100.0%</b>	<b>101</b>	<b>52.9%</b>	<b>90</b>	<b>47.1%</b>
<b>Нийт зээлийн үлдэгдэл</b>	<b>212,482,939.37</b>	<b>100.0%</b>	<b>162,546,862.15</b>	<b>76.5%</b>	<b>49,936,077.23</b>	<b>23.5%</b>
<b>Нийт зээлдэгчийн тоо</b>	<b>31,248</b>	<b>100.0%</b>	<b>14,640</b>	<b>46.9%</b>	<b>16,608</b>	<b>53.1%</b>
Иргэн	31,150	99.7%	14,558	99.4%	16,592	99.9%
Эмэгтэй	16,781	53.7%	8,420	57.5%	8,361	50.3%
Хуулийн этгээд	98	0.3%	82	0.6%	16	0.1%
<b>Зээлдэгчдийн насжилт</b>	<b>31,150</b>	<b>100.0%</b>	<b>14,558</b>	<b>46.7%</b>	<b>16,592</b>	<b>53.3%</b>
18-35 насны	8,363	26.8%	4,286	29.4%	4,077	24.6%
36-45 насны	9,714	31.2%	4,615	31.7%	5,099	30.7%
46-55 насны	9,083	29.2%	4,461	30.6%	4,622	27.9%
55-аас дээш	3,990	12.8%	1,196	8.2%	2,794	16.8%
<b>Зээлдэгчдийн боловсрол</b>	<b>31,150</b>	<b>100.0%</b>	<b>14,558</b>	<b>46.7%</b>	<b>16,592</b>	<b>53.3%</b>
Дээд	11,578	37.2%	6,498	44.6%	5,080	30.6%
Тусгай дунд	6,075	19.5%	3,320	22.8%	2,755	16.6%
Бүрэн дунд	6,795	21.8%	2,147	14.7%	4,648	28.0%
Дунд	5,251	16.9%	2,512	17.3%	2,739	16.5%
Бага	1,451	4.6%	81	0.6%	1,370	8.3%

Тайлант улиралд ХЗХ-д 31,248 зээлдэгчийн 212,482,939.37 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Нийт зээлдэгчийн 46.9 хувь буюу 14,640 зээлдэгч Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүд ба нийт зээлийн 76.5 хувь буюу 162,546,862.15 мянган төгрөгийг бүрдүүлж байна. Харин 53.1 хувь буюу 16,608 зээлдэгч орон нутгийн ХЗХ-дын гишүүд ба нийт зээлийн 23.5 хувь буюу

49,936,077.23 мянган төгрөгийг бүрдүүлж байна.

Нийт зээлдэгчийн 99.7 хувь буюу 31,150 нь хувь хүн (53.7 хувь буюу 16,781 нь эмэгтэй), 0.3 хувь буюу 98 нь хуулийн этгээд байна.

Нэг зээлдэгчид ногдох дундаж зээл 6,799.89 мянган төгрөг байгаа бөгөөд тус үзүүлэлт Улаанбаатар хотод 11,102.93 мянган төгрөг, орон нутагт 3,006.75 мянган төгрөг байна.

Хүснэгт 5: ХЗХ-дын хадгаламж эзэмшигчдийн статистик үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Статистик мэдээлэл	ХЗХ-дын нийт хадгаламж эзэмшигч		Үүнээс:			
			Улаанбаатар хот		Орон нутаг	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
<b>ХЗХ-дын тоо</b>	<b>191</b>	<b>100.0%</b>	<b>101</b>	<b>52.9%</b>	<b>90</b>	<b>47.1%</b>
<b>Нийт хадгаламжийн үлдэгдэл</b>	<b>191,450,152.31</b>	<b>100.0%</b>	<b>151,698,034.24</b>	<b>79.2%</b>	<b>39,752,118.07</b>	<b>20.8%</b>
Нийт хадгаламж эзэмшигчийн тоо	40,340	100.0%	20,958	52.0%	19,382	48.0%
Эмэгтэй	22,486	55.7%	11,051	52.7%	11,435	59.0%
<b>Хугацаагүй хадгаламжийн үлдэгдэл</b>	<b>2,926,147.07</b>	<b>1.5%</b>	<b>2,384,989.22</b>	<b>1.6%</b>	<b>541,157.85</b>	<b>1.4%</b>
Хугацаагүй хадгаламж эзэмшигчийн тоо	4,026	10.0%	2,947	14.1%	1,079	5.6%
Иргэн	4,008	10.0%	2,930	14.0%	1,078	5.6%
Хуулийн этгээд	18	0.0%	17	0.1%	1	0.0%
<b>Хугацаатай хадгаламжийн үлдэгдэл</b>	<b>188,524,005.23</b>	<b>98.5%</b>	<b>149,313,045.02</b>	<b>98.4%</b>	<b>39,210,960.22</b>	<b>98.6%</b>
Хугацаатай хадгаламж эзэмшигчийн тоо	36,314	90.0%	18,011	85.9%	18,303	94.4%
Иргэн	36,266	89.9%	17,996	85.9%	18,270	94.3%
Хуулийн этгээд	48	0.1%	15	0.0%	33	0.1%
<b>Хадгаламж эзэмшигчдийн насжилт</b>	<b>40,274</b>	<b>100.0%</b>	<b>20,926</b>	<b>100.0%</b>	<b>19,348</b>	<b>100.0%</b>
18-35 насны	13,997	34.8%	8,534	40.8%	5,463	28.2%
36-45 насны	10,935	27.1%	5,439	26.0%	5,496	28.4%
46-55 насны	8,695	21.6%	3,955	18.9%	4,740	24.5%
55-аас дээш	6,647	16.5%	2,998	14.3%	3,649	18.9%
<b>Хадгаламж эзэмшигчдийн боловсрол</b>	<b>40,274</b>	<b>100.0%</b>	<b>20,926</b>	<b>100.0%</b>	<b>19,348</b>	<b>100.0%</b>
Дээд	17,863	44.3%	12,039	57.5%	5,824	30.1%
Тусгай дунд	6,558	16.3%	3,413	16.3%	3,145	16.3%
Бүрэн дунд	8,648	21.5%	3,560	17.0%	5,088	26.3%
Дунд	4,262	10.6%	833	4.0%	3,429	17.7%
Бага	2,943	7.3%	1,081	5.2%	1,862	9.6%

2023 оны 1 дүгээр улирлын байдлаар ХЗХ-д 40,340 хадгаламж эзэмшигчийн 191,450,152.31 мянган төгрөгийн хадгаламжийг татан төвлөрүүлсэн байна. Нийт хадгаламж эзэмшигчийн 52.0 хувь буюу 20,958 хадгаламж эзэмшигч Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүд ба нийт хадгаламжийн 79.2 хувь буюу 151,698,034.24 мянган төгрөгийг бүрдүүлж байна. Харин 48.0 хувь буюу 19,382 хадгаламж эзэмшигч нь орон нутгийн ХЗХ-дын гишүүд ба нийт хадгаламжийн 20.8 хувь буюу 39,752,118.07 мянган төгрөгийг бүрдүүлж байна.

Нийт хадгаламж эзэмшигчийн 1.5 хувийг хугацаагүй, 98.5 хувийг хугацаатай хадгаламжтай гишүүд эзэлж байна.

Нийт хадгаламж эзэмшигчийн 99.8 хувь буюу 40,274 нь хувь хүн (55.7 хувь буюу 22,486 нь эмэгтэй), 0.2 хувь буюу 66 нь хуулийн этгээд байна.

Нэг хадгаламж эзэмшигчид ногдох дундаж хадгаламж 4,745.91 мянган төгрөг байгаа бөгөөд тус үзүүлэлт Улаанбаатар хотод 7,238.19 мянган төгрөг, орон нутагт 2,050.98 мянган төгрөг байна.

## 2.2 Санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд

2023 оны 1 дүгээр улирлын байдлаар ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгө 274,547,935.26 мянган төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.7 хувь буюу 16,744,737.09 мянган төгрөгөөр буурч банкны зах зээлийн 0.6 хувьтай тэнцэж байна.

Тайлант улиралд нийт зээлийн үлдэгдэл 3.1 хувь буюу 6,804,007.37 мянган төгрөгөөр,

нийт татан төвлөрүүлсэн хадгаламж 5.3 хувь буюу 10,659,995.94 мянган төгрөгөөр тус тус буурсан үзүүлэлттэй байна. Зах зээлийн нийт орлого 3.4 хувь буюу 558,234.57 мянган төгрөгөөр буурч, нийт зарлага 7.5 хувь буюу 986,058.55 мянган төгрөгөөр нэмэгдсэнээр нийт цэвэр орлого 48.3 хувь буюу 1,544,293.13 мянган төгрөгөөр буурч 1,652,484.29 мянган төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 6: ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Үндсэн үзүүлэлтүүд	2022 оны I улирал	2023 оны I улирал	Өөрчлөлт	
			дүн	хувь
<b>Нийт хөрөнгө</b>	291,292,672.35	274,547,935.26	-16,744,737.09	-5.7%
Банкны салбарт эзлэх хувь	0.7%	0.6%		
<b>Нийт зээл</b>	219,286,946.74	212,482,939.37	-6,804,007.37	-3.1%
Банкны салбарт эзлэх хувь	1.0%	0.9%		
<b>Нийт чанаргүй зээл</b>	7,038,883.68	7,516,805.43	477,921.75	6.8%
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	3.2%	3.5%	0.3%	10.2%
Банкны салбарт эзлэх хувь	0.3%	0.3%	0.0%	1.9%
<b>Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж</b>	202,110,148.25	191,450,152.31	-10,659,995.94	-5.3%
Банкны салбарт эзлэх хувь	1.2%	1.1%		
<b>Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө</b>	26,397,988.26	26,570,075.81	172,087.55	0.7%
<b>Нийт хоршоологчдын өмч</b>	39,123,488.67	32,601,894.64	-6,521,594.03	-16.7%
<b>Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл</b>	7,450,914.24	8,128,728.84	677,814.60	9.1%
Нийт орлого	16,306,590.35	15,748,355.78	-558,234.57	-3.4%
Нийт зарлага	13,109,812.93	14,095,871.48	986,058.55	7.5%
<b>Цэвэр орлого, алдагдал</b>	<b>3,196,777.42</b>	<b>1,652,484.29</b>	<b>-1,544,293.13</b>	<b>-48.3%</b>

### 2.2.1 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 101 ХЗХ-ны нийт хөрөнгө 214,787,684.19 мянган төгрөг нь зах зээлийн 78.2 хувь, нийт зээл 162,546,862.15 мянган төгрөг нь зах зээлийн 76.5 хувь, нийт хадгаламж 151,698,034.24 мянган төгрөг нь зах зээлийн 79.2 хувийг тус тус бүрдүүлж байна. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.2 хувь буюу 263,083.17 мянган төгрөгөөр нэмэгдэж 6,539,132.44 мянган төгрөгт хүрсэн нь нийт зээлийн 4.0 хувийг эзэлж байна. Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл өмнөх оны мөн үеэс 10.4 хувь буюу 763,914.60 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Нийт орлого өмнөх оны мөн үеэс 6.2 хувь буюу 769,864.22 мянган

төгрөгөөр буурч, нийт зарлага 7.9 хувь буюу 782,340.22 мянган төгрөгөөр нэмэгдсэнээр нийт цэвэр орлого 64.7 хувь буюу 1,552,205.02 мянган төгрөгөөр буурч 845,366.90 мянган төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна.

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу Монголбанкнаас ЗМС-ийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгосон “Титан Си Ар Эй ЗМС” ХХК, “Бүрэн скор ЗМС” ХХК-тай Улаанбаатар хотын ХЗХ-дын 52.5 хувь буюу 53 ХЗХ мэдээлэл өгөх, авах гэрээ байгуулсан байна.

Хүснэгт 7: Улаанбаатар хотын ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Үндсэн үзүүлэлтүүд	2022 оны I улирал	2023 оны I улирал	Өөрчлөлт	
			дүн	хувь
<b>Нийт хөрөнгө</b>	237,520,386.27	214,787,684.19	-22,732,702.08	-9.6%
ХЗХ-ны нийт хөрөнгөд эзлэх хувь	81.5%	78.2%	-3.3%	-4.1%
<b>Нийт зээл</b>	173,391,475.20	162,546,862.15	-10,844,613.06	-6.3%
ХЗХ-ны нийт зээлд эзлэх хувь	79.1%	76.5%	-2.6%	-3.3%
<b>Нийт чанаргүй зээл</b>	6,276,049.27	6,539,132.44	263,083.17	4.2%
ХЗХ-ны нийт чанаргүй зээлд эзлэх хувь	89.2%	87.0%	-2.2%	-2.4%
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	3.6%	4.0%	0.4%	11.1%
<b>Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж</b>	165,520,910.79	151,698,034.24	-13,822,876.56	-8.4%
ХЗХ-ны нийт хадгаламжид эзлэх хувь	81.9%	79.2%	-2.7%	-3.2%
<b>Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө</b>	19,845,383.49	19,496,643.57	-348,739.92	-1.8%
ХЗХ-ны нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгөд эзлэх хувь	75.2%	73.4%	-1.8%	-2.4%
<b>Нийт хоршоологчдын өмч</b>	31,897,414.01	23,584,616.62	-8,312,797.39	-26.1%
ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь	81.5%	72.3%	-9.2%	-11.3%
<b>Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл</b>	7,354,814.24	8,118,728.84	763,914.60	10.4%
Нийт орлого	12,343,986.31	11,574,122.09	-769,864.22	-6.2%
Нийт зарлага	9,946,414.39	10,728,755.19	782,340.80	7.9%
<b>Цэвэр орлого, алдагдал</b>	<b>2,397,571.92</b>	<b>845,366.90</b>	<b>-1,552,205.02</b>	<b>-64.7%</b>

## 2.2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 90 ХЗХ-ны нийт хөрөнгө 59,760,251.06 мянган төгрөг нь зах зээлийн 21.8 хувь, нийт зээлийн үлдэгдэл 49,936,077.23 мянган төгрөг нь зах зээлийн 23.5 хувь, нийт хадгаламж 39,752,118.07 мянган төгрөг нь зах зээлийн 20.8 хувийг тус тус эзэлж байна. Нийт орлого өмнөх оны мөн үеэс 5.3 хувь буюу 211,629.65 мянган төгрөг, нийт зарлага 6.4 хувь буюу 203,717.76 мянган төгрөгөөр тус тус өсч, цэвэр орлого 1.0 хувь буюу 7,911.89 мянган төгрөгөөр нэмэгдэж 807,117.39 мянган төгрөгт хүрсэн байна.

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу Монголбанкнаас ЗМС-ийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгосон “Титан Си Ар Эй ЗМС” ХХК, “Бүрэн скор ЗМС” ХХК-тай орон нутгийн ХЗХ-дын 47.8 хувь буюу 43 ХЗХ мэдээлэл өгөх, авах гэрээ байгуулсан байна.

Хүснэгт 8: Орон нутгийн ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Үндсэн үзүүлэлтүүд	2022 оны I улирал	2023 оны I улирал	Өөрчлөлт	
			дүн	хувь
<b>Нийт хөрөнгө</b>	53,772,286.08	59,760,251.06	5,987,964.98	11.1%
ХЗХ-ны нийт хөрөнгөд эзлэх хувь	18.5%	21.8%	3.3%	17.9%
<b>Нийт зээл</b>	45,895,471.54	49,936,077.23	4,040,605.69	8.8%
ХЗХ-ны нийт зээлд эзлэх хувь	20.9%	23.5%	2.6%	12.3%
<b>Нийт чанаргүй зээл</b>	762,834.41	977,672.99	214,838.58	28.2%
ХЗХ-ны нийт чанаргүй зээлд эзлэх хувь	10.8%	13.0%	2.2%	20.0%
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	1.7%	0.6%	-1.1%	-63.8%
<b>Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж</b>	36,589,237.45	39,752,118.07	3,162,880.62	8.6%
ХЗХ-ны нийт хадгаламжид эзлэх хувь	18.1%	20.8%	2.7%	14.7%
<b>Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө</b>	6,552,604.77	7,073,432.24	520,827.47	7.9%
ХЗХ-ны нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгөд эзлэх хувь	24.8%	26.6%	1.8%	7.2%
<b>Нийт хоршоологчдын өмч</b>	7,226,074.66	9,017,278.02	1,791,203.36	24.8%
ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь	18.5%	27.7%	9.2%	49.8%
<b>Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл</b>	96,100.00	10,000.00	-86,100.00	-89.6%
Нийт орлого	3,962,604.04	4,174,233.69	211,629.65	5.3%
Нийт зарлага	3,163,398.54	3,367,116.30	203,717.76	6.4%
<b>Цэвэр орлого, алдагдал</b>	<b>799,205.50</b>	<b>807,117.39</b>	<b>7,911.89</b>	<b>1.0%</b>

## ГУРАВ. НИЙТ ХӨРӨНГИЙН БҮТЭЦ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 3.1 Хөрөнгийн бүтцийн талаар

Хүснэгт 9: ХЗХ-дын хөрөнгийн бүтэц /мянган төгрөгөөр/

ХӨРӨНГӨ	2022 оны I улирал		2023 оны I улирал		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
<b>Эргэлтийн хөрөнгө</b>	<b>280,350,566.01</b>	<b>96.2%</b>	<b>270,451,058.55</b>	<b>98.5%</b>	<b>-9,899,507.46</b>	<b>-3.5%</b>
<b>Мөнгөн хөрөнгө</b>	<b>51,208,991.71</b>	<b>17.6%</b>	<b>42,491,357.22</b>	<b>15.5%</b>	<b>-8,717,634.50</b>	<b>-17.0%</b>
Бэлэн мөнгө	7,529,826.05	2.6%	5,031,679.67	1.8%	-2,498,146.38	-33.2%
Банкинд байршуулсан харилцах	7,219,702.95	2.5%	8,220,527.08	3.0%	1,000,824.13	13.9%
Банкинд байршуулсан хадгаламж	36,459,462.72	12.5%	29,239,150.47	10.6%	-7,220,312.25	-19.8%
<b>Богино хугацаат хөрөнгө оруулалт</b>	<b>150,000.00</b>	<b>0.1%</b>	<b>700,000.00</b>	<b>0.3%</b>	<b>550,000.00</b>	<b>366.7%</b>
Арилжааны үнэт цаас	150,000.00	0.1%	700,000.00	0.3%	550,000.00	366.7%
<b>Зээл /цэврээр/</b>	<b>213,675,151.76</b>	<b>73.4%</b>	<b>207,853,296.94</b>	<b>75.7%</b>	<b>-5,821,854.82</b>	<b>-2.7%</b>
Нийт зээл	219,286,946.74	75.3%	212,482,939.37	77.4%	-6,804,007.37	-3.1%
Хэвийн зээл	206,922,852.69	71.0%	196,564,430.65	71.6%	-10,358,422.04	-5.0%
Хугацаа хэтэрсэн зээл	5,325,210.37	1.8%	8,401,703.29	3.1%	3,076,492.92	57.8%
Чанаргүй зээл	7,038,883.68	2.4%	7,516,805.43	2.7%	477,921.75	6.8%
(Зээлийн эрсдэлийн сан )	5,611,794.98	1.9%	4,629,642.43	1.7%	-982,152.54	-17.5%
<b>Авлага</b>	<b>11,683,114.49</b>	<b>4.0%</b>	<b>17,300,657.90</b>	<b>6.3%</b>	<b>5,617,543.41</b>	<b>48.1%</b>
Байгууллага, хүмүүсээс авах авлага	1,450,332.96	0.5%	7,947,599.46	2.9%	6,497,266.50	448.0%
Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	10,232,781.54	3.5%	9,353,058.44	3.4%	-879,723.09	-8.6%
<b>Бусад эргэлтийн хөрөнгө</b>	<b>2,967,519.25</b>	<b>1.0%</b>	<b>1,133,524.41</b>	<b>0.4%</b>	<b>-1,833,994.83</b>	<b>-61.8%</b>
<b>Өмчлөх бусад хөрөнгө /цэвр/</b>	<b>665,788.79</b>	<b>0.2%</b>	<b>972,222.08</b>	<b>0.4%</b>	<b>306,433.29</b>	<b>46.0%</b>
Өмчлөх бусад хөрөнгө	704,102.11	0.2%	1,010,535.40	0.4%	306,433.29	43.5%
(Өмчлөх бусад хөрөнгийн хасагдуулга)	38,313.32	0.0%	38,313.32	0.0%	0.00	0.0%
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>10,942,106.34</b>	<b>3.8%</b>	<b>4,096,876.71</b>	<b>1.5%</b>	<b>-6,845,229.64</b>	<b>-62.6%</b>
<b>Үндсэн хөрөнгө /цэвр/</b>	<b>3,723,623.30</b>	<b>1.3%</b>	<b>3,877,771.50</b>	<b>1.4%</b>	<b>154,148.20</b>	<b>4.1%</b>
Үндсэн хөрөнгө	5,781,841.65	2.0%	6,307,367.08	2.3%	525,525.43	9.1%
(Хуримтлагдсан элэгдэл)	2,058,218.35	0.7%	2,429,595.58	0.9%	371,377.24	18.0%
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>7,202,995.25</b>	<b>2.5%</b>	<b>203,602.52</b>	<b>0.1%</b>	<b>-6,999,392.73</b>	<b>-97.2%</b>
Биет бус хөрөнгө	7,283,372.66	2.5%	324,077.58	0.1%	-6,959,295.07	-95.6%
(Биет бус хөрөнгийн элэгдэл)	80,377.41	0.0%	120,475.06	0.0%	40,097.66	49.9%
<b>Хөрөнгө оруулалт, бусад хөрөнгө</b>	<b>15,487.79</b>	<b>0.0%</b>	<b>15,502.69</b>	<b>0.0%</b>	<b>14.89668</b>	<b>0.1%</b>
Хөрөнгө оруулалт, бусад хөрөнгө	15,487.79	0.0%	15,502.69	0.0%	14.89668	0.1%
<b>Хөрөнгийн дүн</b>	<b>291,292,672.35</b>	<b>100.0%</b>	<b>274,547,935.26</b>	<b>100.0%</b>	<b>-16,744,737.09</b>	<b>-5.7%</b>

Зураг 4: Хөрөнгийн зарим үзүүлэлтээс /мянган төгрөгөөр/




2023 оны 1 дүгээр улирлын байдлаар ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгө 274,547,935.26 мянган төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.7 хувь буюу 16,744,737.09 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Зах зээлийн нийт хөрөнгийн 98.5 хувийг эргэлтийн хөрөнгө, 1.5 хувийг эргэлтийн бус хөрөнгө бүрдүүлж байгаа бол мөнгөн хөрөнгө нийт хөрөнгийн 15.5 хувийг, цэвр зээл 75.7 хувийг тус тус эзэлж байна.

Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 3.1 хувь буюу 6,804,007.37 мянган төгрөгөөр буурч 212,482,939.37 мянган төгрөгт хүрсэн бөгөөд 4,629,642.43 мянган төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 207,853,296.94 мянган төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй байна. Харин хугацаа хэтэрсэн зээл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 57.8 хувь буюу 3,076,492.92 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгийн өөрчлөлтийг сүүлийн 5 жилээр харьцуулахад 2019-2022 онуудад тусгай зөвшөөрөлтэй ХЗХ-дын тоо буурсан ч хөрөнгийн хэмжээ тасралтгүй өссөн

үзүүлэлттэй байна. Харин 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт активын хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад буурсан үзүүлэлттэй гарсан байна.

График 6: ХЗХ-дын тоо болон нийт хөрөнгийн өөрчлөлт /тэрбум төгрөгөөр/




### 3.2 Хөрөнгийн төвлөрлийн талаар

ХЗХ-дыг хөрөнгийн хэмжээгээр нь ангилахад 10 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгөтэй 4 ХЗХ-ны нийт хөрөнгө 159,276,284.22 мянган төгрөг нь зах зээлийн нийт хөрөнгийн 58.0 хувийг, гишүүдийн тоо 19,151 байгаа нь нийт гишүүдийн 27.4 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 10: ХЗХ-дын хөрөнгийн төвлөрөл, интервалаар /мянган төгрөгөөр/

№	Хөрөнгийн хэмжээ	ХЗХ-дын тоо	Нийт хөрөнгө		Гишүүд	
			Дүн	Хувь	Тоо	Хувь
1	10,000,000.0-аас дээш	4	159,276,284.22	58.0%	19,151	27.4%
2	1,000,000.0 -10,000,000.0	26	79,929,111.23	29.1%	23,310	33.3%
3	500,000.0-1,000,000.0	22	15,684,371.01	5.7%	8,865	12.7%
4	100,000.0-500,000.0	71	15,493,103.26	5.6%	12,928	18.5%
5	50,000.0-100,000.0	45	3,436,202.51	1.3%	4,386	6.3%
6	10,000.0-50,000.0	23	728,863.03	0.3%	1,322	1.9%
7	10,000.0 хүртэл	0	0.00	0.0%	0	0.0%
<b>Нийт дүн</b>		<b>191</b>	<b>274,547,935.26</b>	<b>100.0%</b>	<b>69,962</b>	<b>100.0%</b>



### 3.3 Зээлийн үйл ажиллагааны талаар

Тайлант улиралд зах зээл дэх нийт зээлийн үлдэгдэл 212,482,939.37 мянган төгрөг буюу нийт хөрөнгийн 77.4 хувь, цэвэр зээлийн үлдэгдэл 207,853,296.94 мянган төгрөг буюу нийт хөрөнгийн 75.7 хувийг тус тус эзэлж байна.

Зээлийн жигнэсэн дундаж хүү сарын 2.3 хувь, тайлант хугацаанд олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 3.3 хувь байна.

1 тэрбум төгрөгөөс дээш зээлийн үлдэгдэлтэй 25 ХЗХ-ны зээлийн дүн зах зээлийн нийт зээлийн 84.8 хувийг бүрдүүлж байна. Тайлант улиралд шинээр хадгаламж,

зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 1 ХЗХ зээлийн үйл ажиллагаа эрхлээгүй байна.

Хүснэгт 11: ХЗХ-дын зээлийн хэмжээ, интервалаар /мянган төгрөгөөр/

№	Зээлийн хэмжээ	ХЗХ-дын тоо	Зээлийн дүн	Эзлэх хувь
1	1,000,000.0 дээш	25	180,185,440.39	84.8%
2	500,000.0-1,000,000.0	17	12,449,004.21	5.9%
3	100,000.0-500,000.0	66	15,429,416.57	7.3%
4	50,000.0-100,000.0	48	3,469,518.67	1.6%
5	10,000.0-50,000.0	30	929,669.83	0.4%
6	10,000.0 хүртэл	4	19,889.70	0.0%
7	Зээлийн үйл ажиллагаа эрхлээгүй	1	-	-
<b>Нийт дүн</b>		<b>191</b>	<b>212,482,939.37</b>	<b>100%</b>

### 3.4 Зээлийн чанарын талаар

Хүснэгт 12: Зээлийн ангиллын мэдээлэл /мянган төгрөгөөр/


Зээлийн ангиллын мэдээлэл	Зээлдэгчийн мэдээлэл		Зээлийн үлдэгдэл	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
<b>Нийт</b>	<b>31,248</b>	<b>100.0%</b>	<b>212,482,939.37</b>	<b>100.0%</b>
Хэвийн	28,876	92.4%	196,564,430.65	92.5%
Хугацаа хэтэрсэн	1,074	3.4%	8,401,703.29	4.0%
Чанаргүй	1,298	4.2%	7,516,805.43	3.5%
<i>Хэвийн бус</i>	373	28.7%	2,772,828.15	36.9%
<i>Эргэлзээтэй</i>	361	27.8%	2,012,651.74	26.8%
<i>Муу</i>	564	43.5%	2,731,325.55	36.3%

2023 оны 1 дүгээр улирлын байдлаар ХЗХ-ны зах зээлийн хэмжээнд нийт зээлийн үлдэгдлийн 92.5 хувь буюу 196,564,430.65 мянган төгрөгийг хэвийн зээл, 4.0 хувь буюу 8,401,703.29 мянган төгрөгийг хугацаа хэтэрсэн зээл, 3.5 хувь буюу 7,516,805.43 мянган төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна. Тайлант хугацаанд хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн 15,918,508.73 мянган төгрөгийн үлдэгдэлд 29.1 хувь буюу 4,629,642.43 мянган төгрөгийн зээлийн эрсдэлийн санг байгуулсан байна. Зээлдэгчдийн мэдээллийг зээлийн чанараар ангилахад нийт зээлдэгчийн 92.4 хувийг хэвийн, 3.4 хувийг хугацаа хэтэрсэн, 4.2 хувийг чанаргүй зээлдэгч эзэлж байна. Чанаргүй зээлийн үлдэгдэлтэй 1,298 зээлдэгчийн 7,516,805.43 мянган төгрөгийн үлдэгдлийн 36.9 хувийг хэвийн бус, 26.8 хувийг эргэлзээтэй, 36.3

хувийг муу зээлийн үлдэгдэлтэй зээлдэгчид тус тус эзэлж байна.

Тайлант улиралд нийт зээлд эзлэх хэвийн зээлийн хувь хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.9 пунктээр буурч 92.5 хувь, хугацаа хэтэрсэн зээлийн хувь хэмжээ 1.5 пунктээр нэмэгдэж 4.0 хувь, чанаргүй зээлийн хувь хэмжээ 0.3 пунктээр нэмэгдэж 3.5 хувьд хүрсэн байна.

График 7: Зээлийн чанар



Хүснэгт 13: Зээлийн ангиллын мэдээлэл хот, орон нутгаар /мянган төгрөгөөр/

Зээлийн ангиллын мэдээлэл	Улаанбаатар хот			Орон нутаг		
	Дүн	Хувь	Нийт дүнд эзлэх хувь	Дүн	Хувь	Нийт дүнд эзлэх хувь
<b>Нийт</b>	<b>162,546,862.15</b>	<b>100.0%</b>	<b>76.5%</b>	<b>49,936,077.23</b>	<b>100.0%</b>	<b>23.5%</b>
Хэвийн	149,438,651.64	91.9%	76.0%	47,125,779.01	94.4%	24.0%
Хугацаа хэтэрсэн	6,569,078.07	4.1%	78.2%	1,832,625.22	3.7%	21.8%
Чанаргүй	6,539,132.44	4.0%	87.0%	977,672.99	1.9%	13.0%
<i>Хэвийн бус</i>	2,417,975.83	37.0%	87.2%	354,852.31	36.3%	12.8%
<i>Эргэлзээтэй</i>	1,718,640.18	26.3%	85.4%	294,011.56	30.1%	14.6%
<i>Муу</i>	2,402,516.43	36.7%	88.0%	328,809.12	33.6%	12.0%

Зээлийн ангиллын мэдээллийг хот, орон нутгаар ангилан харвал ХЗХ-ны зах зээлийн нийт зээлийн 76.5 хувь буюу 162,546,862.15 мянган төгрөгийг Улаанбаатар хотын ХЗХ-

д, 23.5 хувь буюу 49,936,077.23 мянган төгрөгийг орон нутгийн ХЗХ-дын зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна. Улаанбаатар хотын ХЗХ-дын зээлийн үлдэгдлийн 91.9

хувь буюу 149,438,651.64 мянган төгрөгийг хэвийн, 4.1 хувь буюу 6,569,078.07 мянган төгрөгийг хугацаа хэтэрсэн, 4.0 хувь буюу 6,539,132.44 мянган төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл эзэлж байна. Чанаргүй зээлийн үлдэгдлийн 36.7 хувь буюу 2,402,516.43 мянган төгрөгийг муу зээлийн үлдэгдэл бүрдүүлж байгаа бөгөөд зах зээлийн нийт муу зээлийн 88.0 хувийг эзэлж байна. Орон нутгийн ХЗХ-дын зээлийн үлдэгдлийн 94.4 хувь буюу 47,125,779.01 мянган төгрөгийг хэвийн, 3.7 хувь буюу 1,832,625.22 мянган төгрөгийг хугацаа хэтэрсэн, 1.9 хувь буюу 977,672.99 мянган

төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

График 8: Зээлийн багцын чанар /тэрбум төгрөгөөр/



Хүснэгт 14: Зээлийн бүтээгдэхүүнээр /мянган төгрөгөөр/

№	ЗЭЭЛИЙН ЗОРИУЛАЛТ	Зээлийн эхний үлдэгдэл /дүн/	Тайлант хугацаанд олгосон зээл	Тайлант хугацаанд эргэн төлөгдсөн зээл	Зээлийн эцсийн үлдэгдэл	Зээлийн үлдэгдлийн нийт зээлд эзлэх хувь
1	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	8,669,900.42	5,001,167.71	4,422,974.78	9,248,093.34	4.3%
2	Уул уурхай, олборлолт	1,917,195.26	437,500.00	323,583.47	2,031,111.79	1.0%
3	Боловсруулах үйлдвэрлэл	2,433,748.56	582,150.00	820,918.98	2,194,979.58	1.0%
4	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	436,421.53	157,622.00	155,799.32	438,244.22	0.2%
5	Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	487,097.04	154,216.10	178,403.01	462,910.13	0.2%
6	Барилга	6,481,881.76	2,761,456.65	1,692,549.92	7,550,788.48	3.6%
7	Бөөний болон жижиглэн худалдаа	17,821,906.76	7,747,576.20	7,606,492.06	17,962,990.91	8.4%
8	Машин мотоциклийн засвар үйлчилгээ	4,286,844.94	1,556,507.36	1,748,243.88	4,095,108.41	1.9%
9	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	2,604,385.34	992,662.80	1,275,621.04	2,321,427.10	1.1%
10	Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	4,982,250.64	1,546,996.67	1,061,854.50	5,467,392.81	2.6%
11	Мэдээлэл холбоо	3,996,354.00	102,000.00	108,094.30	3,990,259.70	1.9%
12	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	19,102,897.26	2,523,800.00	2,063,697.10	19,563,000.15	9.2%
13	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	2,012,154.15	369,180.54	336,522.17	2,044,812.52	1.0%
14	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	640,879.42	44,800.00	113,302.50	572,376.92	0.3%
15	Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	284,546.01	57,886.00	56,574.89	285,857.12	0.1%
16	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	38,628.89	0.00	25,078.38	13,550.50	0.0%
17	Боловсрол	1,463,321.22	1,011,104.67	953,756.08	1,520,669.81	0.7%
18	Хүний эрүүл мэнд, нийгмийн үйл ажиллагаа	869,936.85	729,296.38	517,741.12	1,081,492.11	0.5%
19	Бусад	131,589,854.32	194,900,282.94	194,852,263.50	131,637,873.76	62.0%
	Үүнээс: Хэрэглээ, цалин, тэтгэвэр, хадгаламж барьцаалсан зээл	20,239,649.53	101,363,379.29	99,175,510.25	22,427,518.58	10.6%
	<b>НИЙТ</b>	<b>210,120,204.35</b>	<b>220,676,206.02</b>	<b>218,313,471.00</b>	<b>212,482,939.37</b>	<b>100.0%</b>

2023 оны 1 дүгээр улирлын байдлаар ХЗХ-д нийт 220,676,206.02 мянган төгрөгийн зээл олгож, 218,313,471.00 мянган төгрөгийн зээлийн эргэн төлөлт хийгдэж 212,482,939.37 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Зээлийн үлдэгдлийг зээлийн бүтээгдэхүүнээр нь ангилахад нийт зээлийн үлдэгдлийн 62.0 хувь буюу 131,637,873.76 мянган төгрөгийг бусад, 9.2 хувь буюу 19,563,000.15 мянган төгрөгийг санхүүгийн болон даатгалын үйл

ажиллагаа, 8.4 хувь буюу 17,962,990.91 мянган төгрөгийг бөөний болон жижиглэнгийн худалдаа, 4.3 хувь буюу 9,248,093.34 мянган төгрөгийг хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур, 3.6 хувь буюу 7,550,788.48 мянган төгрөгийг барилгын зориулалтаар тус тус авсан байна. Мөн нийт зээлийн үлдэгдлийн 10.6 хувь буюу 22,427,518.58 мянган төгрөгийг хэрэглээ, цалин, тэтгэвэр, хадгаламж барьцаалсан зээл эзэлж байна.

## ДӨРӨВ. НИЙТ ЭХ ҮҮСВЭРИЙН БҮТЭЦ, ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА


### 4.1 Эх үүсвэрийн бүтцийн талаар

Хүснэгт 15: ХЗХ-дын эх үүсвэрийн бүтэц (мянган төгрөгөөр)

ЭХ ҮҮСВЭР	2022 оны I улирал		2023 оны I улирал		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
<b>Өр төлбөр</b>	<b>225,606,636.24</b>	<b>77.5%</b>	<b>215,178,529.45</b>	<b>78.3%</b>	<b>-10,428,106.79</b>	<b>-4.6%</b>
Хадгаламж	202,110,148.25	69.4%	191,450,152.31	69.7%	-10,659,995.94	-5.3%
Хугацаагүй	3,332,786.78	1.1%	2,926,147.07	1.1%	-406,639.71	-12.2%
Хугацаатай	198,777,361.47	68.2%	188,524,005.23	68.6%	-10,253,356.23	-5.2%
<b>Богино хугацаат зээл</b>	<b>3,534,187.77</b>	<b>1.2%</b>	<b>2,479,961.58</b>	<b>0.9%</b>	<b>-1,054,226.18</b>	<b>-29.8%</b>
<b>Бусад богино хугацаат өр төлбөр</b>	<b>15,917,293.22</b>	<b>5.5%</b>	<b>15,463,996.57</b>	<b>5.6%</b>	<b>-453,296.65</b>	<b>-2.8%</b>
<b>Урт хугацаат өр төлбөр</b>	<b>4,045,007.01</b>	<b>1.4%</b>	<b>5,784,418.99</b>	<b>2.1%</b>	<b>1,739,411.98</b>	<b>43.0%</b>
<b>Өөрийн хөрөнгө</b>	<b>65,686,036.11</b>	<b>22.5%</b>	<b>59,369,405.81</b>	<b>21.7%</b>	<b>-6,316,630.30</b>	<b>-9.6%</b>
<b>Гишүүдийн оруулсан хувь хөрөнгө</b>	<b>26,397,988.26</b>	<b>9.0%</b>	<b>26,570,075.81</b>	<b>9.7%</b>	<b>172,087.55</b>	<b>0.7%</b>
Гишүүний оруулсан хувь хөрөнгө	18,900,077.40	6.5%	26,327,035.93	9.6%	7,426,958.53	39.3%
Идэвхгүй гишүүний хувь хөрөнгө	7,497,910.86	2.5%	243,039.88	0.1%	-7,254,870.98	-96.8%
<b>Дахин үнэлгээний нэмэгдэл</b>	<b>164,559.17</b>	<b>0.1%</b>	<b>197,435.35</b>	<b>0.1%</b>	<b>32,876.18</b>	<b>20.0%</b>
<b>Хоршоологчдын өмч</b>	<b>39,123,488.67</b>	<b>13.4%</b>	<b>32,601,894.64</b>	<b>11.9%</b>	<b>-6,521,594.03</b>	<b>-16.7%</b>
Нөөцийн сан	11,598,487.30	4.0%	12,531,871.83	4.6%	933,384.53	8.0%
Хандив, тусламж	331,015.87	0.1%	358,504.64	0.1%	27,488.77	8.3%
Хадгаламж, хамгаалалтын сан	2,592,716.04	0.9%	2,845,751.89	1.0%	253,035.85	9.8%
Нийгмийн хөгжлийн сан	1,289,510.71	0.4%	1,530,860.64	0.6%	241,349.93	18.7%
Тогтворжилтын сан	2,559,299.35	0.9%	2,832,832.26	1.0%	273,532.91	10.7%
Бусад сангууд	1,762,064.73	0.6%	2,351,329.59	0.9%	589,264.86	33.4%
Хуримтлагдсан орлого /алдагдал/	18,990,394.68	6.5%	10,150,743.80	3.7%	-8,839,650.88	-46.5%
Тайлангийн үеийн цэвэр орлого	3,196,777.42	1.1%	1,652,484.29	0.6%	-1,544,293.13	-48.3%
Өмнөх үеийн цэвэр орлого	15,793,617.26	5.4%	8,498,259.51	3.1%	-7,295,357.75	-46.2%
<b>Нийт өр төлбөр ба өөрийн</b>	<b>291,292,672.35</b>	<b>100.0%</b>	<b>274,547,935.26</b>	<b>100.0%</b>	<b>-16,744,737.09</b>	<b>-5.7%</b>

Зах зээлийн нийт өр төлбөр 215,178,529.45 мянган төгрөгийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.6 хувь буюу 10,428,106.79 мянган төгрөгөөр, өөрийн хөрөнгө 59,369,405.81 мянган төгрөг нь 9.6 хувь буюу 6,316,630.30 мянган төгрөгөөр тус тус буурсан үзүүлэлттэй байна. Эх үүсвэрийн бүтцийн 78.3 хувийг өр төлбөр, 21.7 хувийг өөрийн хөрөнгө бүрдүүлж байна.

График 9: Өр төлбөр болон өөрийн хөрөнгийн үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/



ХЗХ-дын татан төвлөрүүлсэн хадгаламж, хоршоологчдын өмч, гишүүдийн хувь хөрөнгийн дүн 2019 оны 1 дүгээр улирлаас 2023 оны 1 дүгээр улирал хүртэлх 5 жилийн

хугацаанд 26.8-101.3 хувь хүртэл нэмэгдсэн байна. Харин бусад өр төлбөрийн дүн нийт 16.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

#### 4.2 Хадгаламжийн үйл ажиллагааны талаар

ХЗХ-ны зах зээлийн татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ 191,450,152.31 мянган төгрөг буюу нийт эх үүсвэрийн 69.7 хувийг эзэлж байна. Нийт хадгаламжийн 98.5 хувийг хугацаатай хадгаламж, 1.5 хувийг хугацаагүй хадгаламж тус тус бүрдүүлж байна.

байна. Тайлант улиралд шинээр хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 1 ХЗХ хадгаламж татан төвлөрүүлээгүй байна.

Хүснэгт 16: ХЗХ-дын хадгаламж, интервалаар /мянган төгрөгөөр/


№	Хадгаламжийн хэмжээ	ХЗХ -д	Хадгаламжийн дүн	Эзлэх хувь
1	10,000,000.0 дээш	4	116,794,689.58	61.0%
2	1,000,000.0-10,000,000.0	15	46,914,613.61	24.5%
3	500,000.0-1,000,000.0	18	13,152,889.00	6.9%
4	100,000.0-500,000.0	46	10,757,256.77	5.6%
5	50,000.0-100,000.0	28	2,124,497.37	1.1%
6	10,000.0-50,000.0	62	1,625,173.17	0.9%
7	5,000.0-10,000.0	8	57,378.38	0.0%
8	5,000.0 хүртэл	9	23,654.43	0.0%
9	Хадгаламжгүй	1	-	-
<b>Нийт дүн</b>		<b>191</b>	<b>191,450,152.31</b>	<b>100.0%</b>

Хугацаатай хадгаламжийн жигнэсэн дундаж хүү сарын 1.3 хувь, тайлант улиралд татан төвлөрүүлсэн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 1.1 хувь байна.

Татан төвлөрүүлсэн хадгаламжийн дүнгээр 10 тэрбум төгрөгөөс дээш хадгаламжтай 4 ХЗХ-ны хадгаламж нийт ХЗХ-дын хадгаламжийн дүнгийн 61.0 хувийг эзэлж

ХЗХ-ны зах зээлийн нийт хадгаламжийн хэмжээ сүүлийн 5 жилд дундаар 5.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

График 10: ХЗХ-ны зах зээлийн хадгаламжийн өөрчлөлт /тэрбум төгрөгөөр/



### 4.3 Бусдаас авсан зээл, өр төлбөрийн талаар

Хүснэгт 17: ХЗХ-дын бусдаас авсан зээлийн бүтэц (мянган төгрөгөөр)

БУСДААС АВСАН ЗЭЭЛ	2022 оны I улирал		2023 оны I улирал		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
<b>Богино хугацаат зээл</b>	<b>3,534,187.77</b>	<b>46.6%</b>	<b>2,479,961.58</b>	<b>30.0%</b>	<b>-1,054,226.18</b>	<b>-29.8%</b>
Банкнаас авсан зээл	1,521,600.34	20.1%	723,000.00	8.7%	-798,600.34	-52.5%
Санхүүгийн байгууллагаас авсан зээл	479,000.00	6.3%	529,000.00	6.4%	50,000.00	10.4%
Төсөл, хөтөлбөрөөс авсан зээл	1,533,587.43	20.2%	1,227,961.58	14.9%	-305,625.85	-19.9%
Тогтворжилтын сангийн туслалцаа	-	0.0%	-	0.0%	-	-
<b>Урт хугацаат өр төлбөр</b>	<b>4,045,007.01</b>	<b>53.4%</b>	<b>5,784,418.99</b>	<b>70.0%</b>	<b>1,739,411.98</b>	<b>43.0%</b>
Банкнаас авсан зээл	-	0.0%	2,179,998.04	26.4%	2,179,998.04	100.0%
Санхүүгийн байгууллагаас авсан зээл	2,003,323.65	26.4%	2,500,000.00	30.3%	496,676.35	24.8%
Төсөл, хөтөлбөрөөс авсан зээл	1,913,402.81	25.2%	968,769.21	11.7%	-944,633.60	-49.4%
Тогтворжилтын сангийн туслалцаа	-	0.0%	50,000.00	0.6%	50,000.00	100.0%
Хойшлогдсон татварын өр төлбөр	128,280.54	1.7%	85,651.73	1.0%	-42,628.81	-33.2%
<b>Нийт дүн</b>	<b>7,579,194.78</b>	<b>100.0%</b>	<b>8,264,380.57</b>	<b>100.0%</b>	<b>685,185.80</b>	<b>9.0%</b>

2023 оны 1 дүгээр улирлын байдлаар ХЗХ-дын бусдаас авсан зээлийн үлдэгдэл 8,264,380.57 мянган төгрөг байгаа нь зах зээлийн нийт хөрөнгийн 3.0 хувийг эзэлж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.0 хувь буюу 685,185.80 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Тайлант улиралд бусдаас авсан нийт зээлийн 30.0 хувийг богино

хугацаат зээл, 70.0 хувийг урт хугацаат өр төлбөр тус тус бүрдүүлж байна. Богино хугацаат зээлийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 29.8 хувь буюу 1,054,226.18 мянган төгрөгөөр буурсан бол урт хугацаат өр төлбөр 43.0 хувь буюу 1,739,411.98 мянган төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 18: ХЗХ-дын бусдаас авсан зээлийн бүтэц, хот, орон нутгаар /мянган төгрөгөөр/

БУСДААС АВСАН ЗЭЭЛ	Нийт		УБ		Орон нутаг	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
Банкнаас авсан зээл	2,902,998.04	35.1%	2,902,998.04	35.4%	0.00	0.0%
Санхүүгийн байгууллагаас авсан зээл	3,029,000.00	36.7%	3,029,000.00	36.9%	0.00	0.0%
Төсөл, хөтөлбөрөөс авсан зээл	2,196,730.80	26.6%	2,186,730.80	26.7%	10,000.00	14.9%
Тогтворжилтын сангийн туслалцаа	50,000.00	0.6%	0.00	0.0%	50,000.00	74.2%
Хойшлогдсон татварын өр төлбөр	85,651.73	1.0%	78,297.39	1.0%	7,354.34	10.9%
<b>Нийт дүн</b>	<b>8,264,380.57</b>	<b>100.0%</b>	<b>8,197,026.23</b>	<b>100.0%</b>	<b>67,354.34</b>	<b>100.0%</b>

ХЗХ-дын бусдаас авсан зээлийн хэмжээнд банкнаас авсан зээл 35.1 хувь, санхүүгийн байгууллагаас авсан зээл 36.7 хувь, төсөл,

хөтөлбөрөөс авсан зээлийн хэмжээ 26.6 хувь, хойшлогдсон татварын өр төлбөр 1.0 хувийг тус тус эзэлж байна.

### 4.4 Бусад богино хугацаат өр төлбөрийн талаар

Хүснэгт 19: ХЗХ-дын бусад богино хугацаат өр төлбөрийн бүтэц /мянган төгрөгөөр/

БУСАД БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2022 оны I улирал		2023 оны I улирал		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
Цалингийн өглөг	139,883.36	0.9%	113,942.70	0.7%	-25,940.66	-18.5%
Татвар, НДШ, ЭМДШ-ийн өглөг	1,551,849.13	9.7%	1,008,793.96	6.5%	-543,055.16	-35.0%
Ногдол ашгийн өглөг	432,958.08	2.7%	639,845.59	4.1%	206,887.51	47.8%
Санхүүгийн түрээсийн өглөг	0.00	0.0%	0.00	0.0%	0.00	0.0%
Санхүүгийн түрээсийн хэрэгжээгүй орлого	0.00	0.0%	0.00	0.0%	0.00	0.0%
Урьдчилж орсон орлого	89,770.21	0.6%	95,256.30	0.6%	5,486.09	6.1%
Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	12,436,480.79	78.1%	12,476,387.56	80.7%	39,906.77	0.3%
Салбар хоорондын тооцоогоорх өглөг	0.00	0.0%	0.00	0.0%	0.00	0.0%
Бусад богино хугацаат өглөг	1,266,351.65	8.0%	1,129,770.46	7.3%	-136,581.20	-10.8%
<b>Нийт дүн</b>	<b>15,917,293.22</b>	<b>100.0%</b>	<b>15,463,996.57</b>	<b>100.0%</b>	<b>-453,296.65</b>	<b>-2.8%</b>

Тайлант улиралд ХЗХ-дын бусад богино хугацаат өр төлбөр 15,463,996.57 мянган төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй

харьцуулахад 453,296.65 мянган төгрөг буюу 2.8 хувиар буурсан бөгөөд зах зээлийн нийт хөрөнгийн 5.6 хувийг эзэлж байна.

#### 4.5 Гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн талаар

Тайлант улиралд гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн хэмжээ 26,570,075.81 мянган төгрөг нь нийт эх үүсвэрийн 9.7 хувийг эзэлж байна.

Хүснэгт 20: ХЗХ-дын гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн хэмжээ, интервалаар /мянган төгрөгөөр/

№	Гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн хэмжээ	ХЗХ-дын тоо	Гишүүдийн тоо		Гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн дүн		Нэг гишүүнд ногдох хувь хөрөнгө Дүн
			Дүн	Хувь	Дүн	Хувь	
1	1,000,000.0 дээш	5	19,819	28.3%	13,984,642.42	52.6%	705.62
2	500,000.0-1,000,000.0	1	364	0.5%	679,367.11	2.6%	1,866.39
3	100,000.0-500,000.0	28	21,158	30.2%	6,896,882.14	26.0%	325.97
4	50,000.0-100,000.0	41	13,666	19.5%	2,776,441.98	10.4%	203.16
5	10,000.0-50,000.0	86	12,746	18.2%	2,034,685.63	7.7%	159.63
6	5,000.0-10,000.0	24	1,834	2.6%	175,167.87	0.7%	95.51
7	5,000.0 хүртэл	6	375	0.5%	22,888.66	0.1%	61.04
<b>Нийт дүн</b>		<b>191</b>	<b>69,962</b>	<b>100.0%</b>	<b>26,570,075.81</b>	<b>100.0%</b>	<b>379.78</b>

Гишүүдийн оруулсан хувь хөрөнгө 100 сая төгрөгөөс дээш 34 ХЗХ

ХЗХ-ны зах зээлийн гишүүдийн оруулсан нийт хувь хөрөнгийн 81.1%

Нийт гишүүдийн 59.1%

#### 4.6 Өөрийн хөрөнгө, хоршоологчдын өмчийн талаар

2023 оны 1 дүгээр улирлын байдлаар ХЗХ-дын өөрийн хөрөнгө 59,369,405.81 мянган төгрөгт хүрч, нийт эх үүсвэрийн 21.6 хувийг эзэлж байна.

Тайлант улиралд 7 ХЗХ-ны нийт өр төлбөрийн хэмжээ нийт хөрөнгөөс хэтэрсэн буюу өөрийн хөрөнгөгүй болсон ба 4 ХЗХ нь “Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр”-ийн хүрээнд байгуулагдсан байна.

Хүснэгт 21: ХЗХ-дын өөрийн хөрөнгийн хэмжээ, интервалаар /мянган төгрөгөөр/

№	Өөрийн хөрөнгийн хэмжээ	ХЗХ-дын тоо	Өөрийн хөрөнгө	
			Дүн	Хувь
1	1,000,000.0 дээш	6	33,444,765.04	56.3%
2	500,000.0-1,000,000.0	15	11,208,314.14	18.9%
3	100,000.0-500,000.0	53	10,615,541.53	17.9%
4	50,000.0-100,000.0	42	2,808,555.84	4.7%
5	10,000.0-50,000.0	56	1,514,761.70	2.6%
6	10,000.0 доош	12	72,907.83	0.1%
7	Өөрийн хөрөнгөгүй	7	-295,440.26	-0.5%
<b>Нийт дүн</b>		<b>191</b>	<b>59,369,405.81</b>	<b>100%</b>

Хүснэгт 22: ХЗХ-дын хоршоологчдын өмч, интервалаар /мянган төгрөгөөр/

№	Хоршоологчдын өмчийн дүн /интервалаар/	ХЗХ-дын тоо	Хоршоологчдын өмчийн дүн	
			Дүн	Хувь
1	1,000,000.0 дээш	5	18,720,913.83	57.4%
2	500,000.0-1,000,000.0	6	3,611,357.61	11.1%
3	100,000.0-500,000.0	36	7,421,141.82	22.8%
4	50,000.0-100,000.0	23	1,590,537.25	4.9%
5	10,000.0-50,000.0	64	1,538,843.66	4.7%
6	5,000.0-10,000.0	20	147,328.86	0.5%
7	1,000.0-5,000.0	19	58,845.76	0.2%
8	1,000.0 хүртэл	3	910.18	0.0%
9	Хоршоологчдын өмчгүй /алдагдалтай/	15	-487,984.34	-1.5%
<b>Нийт дүн</b>		<b>191</b>	<b>32,601,894.64</b>	<b>100.0%</b>

Тайлант улиралд нийт 15 ХЗХ алдагдалтай ажилласны улмаас хоршоологчдын өмчгүй болсон ба өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6 ХЗХ буюу 28.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

## ТАВ. ОРЛОГО, ЗАРЛАГА, АШИГТ АЖИЛЛАГАА

### 5.1 ХЗХ-дын орлогын талаар

Тайлант улиралд зах зээлийн нийт орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.4 хувь буюу 558,234.57 мянган төгрөгөөр буурч 15,748,355.78 мянган төгрөгт хүрсэн байна. Нийт орлогын 92.7 хувь нь хүүгийн орлого, 1.4 хувь нь үйл ажиллагааны бусад орлого, 5.9 хувь нь үйл ажиллагааны бус орлого

*Хүснэгт 23: ХЗХ-дын орлогын бүтэц (мянган төгрөгөөр)*

ҮЗҮҮЛЭЛТ	2022 оны I улирал		2023 оны I улирал		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
<b>1. Хүүгийн орлого</b>	<b>15,254,025.07</b>	<b>93.5%</b>	<b>14,602,092.40</b>	<b>92.7%</b>	<b>-651,932.68</b>	<b>-4.3%</b>
Зээлийн хүүгийн орлого	14,160,940.81	86.8%	13,681,764.90	86.9%	-479,175.91	-3.4%
Зээлийн нэмэгдүүлсэн хүүгийн орлого	50,184.88	0.3%	93,192.23	0.6%	43,007.35	85.7%
Үнэт цаасны хүүгийн орлого	-	0.0%	-	0.0%	-	0.0%
Банк, санхүүгийн байгууллагаас авсан хүүгийн орлого	988,769.22	6.1%	833,465.61	5.3%	-155,303.61	-15.7%
Санхүүгийн түрээсийн хүүгийн орлого	63,760.16	0.4%	-	0.0%	-63,760.16	-100.0%
(Зээлийн хүүгийн орлогын буцаалт)	9,630.00	0.1%	6,330.35	0.0%	-3,299.65	-34.3%
<b>2. Үйл ажиллагааны бусад орлого</b>	<b>369,000.64</b>	<b>2.3%</b>	<b>216,620.10</b>	<b>1.4%</b>	<b>-152,380.54</b>	<b>-41.3%</b>
<b>3. Үйл ажиллагааны бус орлого</b>	<b>683,564.64</b>	<b>4.2%</b>	<b>929,643.28</b>	<b>5.9%</b>	<b>246,078.64</b>	<b>36.0%</b>
<b>Нийт орлого</b>	<b>16,306,590.35</b>	<b>100.0%</b>	<b>15,748,355.78</b>	<b>100.0%</b>	<b>-558,234.57</b>	<b>-3.4%</b>

### 5.2 ХЗХ-дын зардлын талаар

ХЗХ-ны зах зээлийн нийт зардлын хэмжээ 14,095,871.48 мянган төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.5 хувь буюу 986,058.55 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Нийт зардлын бүтцэд хүүгийн зардал 60.5 хувь, үйл ажиллагааны зардал 28.8 хувь, болзошгүй эрсдэлийн

байна. Зээлийн хүүгийн орлого 13,681,764.90 мянган төгрөг нь нийт орлогын 86.9 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.4 хувь буюу 479,175.91 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

сангийн зардал 9.2 хувь, үйл ажиллагааны бус зардал 0.1 хувийг тус тус эзэлж байна. Хүүгийн зардал 8,525,195.47 мянган төгрөгт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.6 хувь буюу 55,004.06 мянган төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 24: ХЗХ-дын зардлын бүтэц /мянган төгрөгөөр/*

ҮЗҮҮЛЭЛТ	2022 оны I улирал		2023 оны I улирал		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
<b>1. Хүүгийн зардал</b>	<b>8,580,199.53</b>	<b>65.4%</b>	<b>8,525,195.47</b>	<b>60.5%</b>	<b>-55,004.06</b>	<b>-0.6%</b>
Хадгаламжийн хүүгийн зардал	8,339,874.72	63.6%	8,138,521.72	57.8%	-201,353.01	-2.4%
Банк, санхүүгийн байгууллагад төлсөн хүүгийн зардал	243,052.53	1.9%	387,170.05	2.7%	144,117.52	59.3%
Санхүүгийн түрээсийн хүүгийн зардал	0.00	0.0%	0.00	0.0%	0.00	0.0%
Бусад хүүгийн зардал	10,569.32	0.1%	11,292.15	0.1%	722.82	6.8%
(Хүүгийн зардлын буцаалт)	13,297.04	0.1%	11,788.45	0.1%	-1,508.60	-11.3%
<b>2. Болзошгүй эрсдэлийн сангийн зардал</b>	<b>415,440.28</b>	<b>3.2%</b>	<b>1,303,331.56</b>	<b>9.2%</b>	<b>887,891.28</b>	<b>213.7%</b>
Зээлийн эрсдэлийн зардал	488,462.47	3.7%	1,341,627.61	9.5%	853,165.13	174.7%
Өмчлөх бусад хөрөнгийн үнэлгээний хасагдуулгын зардал	3,000.00	0.0%	0.00	0.0%	-3,000.00	-100.0%
(Болзошгүй эрсдэлийн сангийн нөхөлт)	76,022.19	0.6%	38,296.04	0.3%	-37,726.15	-49.6%
<b>3. Үйл ажиллагааны зардал</b>	<b>3,815,233.25</b>	<b>29.1%</b>	<b>4,052,344.35</b>	<b>28.8%</b>	<b>237,111.10</b>	<b>6.2%</b>
Боловсон хүчний зардал	2,376,874.70	18.1%	2,633,494.73	18.7%	256,620.02	10.8%
Бусад төрлийн зардал	1,438,358.54	11.0%	1,418,849.63	10.1%	-19,508.92	-1.4%
<b>4. Үйл ажиллагааны бус зардал</b>	<b>16,648.97</b>	<b>0.1%</b>	<b>16,421.21</b>	<b>0.1%</b>	<b>-227.76</b>	<b>-1.4%</b>
<b>Татварын зардал</b>	<b>282,290.90</b>	<b>2.2%</b>	<b>198,578.88</b>	<b>1.4%</b>	<b>-83,712.02</b>	<b>-29.7%</b>
<b>Нийт зардал</b>	<b>13,109,812.93</b>	<b>100.0%</b>	<b>14,095,871.48</b>	<b>100.0%</b>	<b>986,058.55</b>	<b>7.5%</b>
<b>Цэвэр орлого</b>	<b>3,196,777.42</b>	<b>100.0%</b>	<b>1,652,484.29</b>	<b>100.0%</b>	<b>-1,544,293.13</b>	<b>-48.3%</b>

### 5.3 ХЗХ-дын ашигт ажиллагааны талаар


2023 оны 1 дүгээр улирлын байдлаар ХЗХ-ны зах зээлийн нийт орлого 15,748,355.78 мянган төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.4 хувь буюу 558,234.57 мянган төгрөгөөр буурч, нийт зардал 14,095,871.48 мянган төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.5 хувь буюу 986,058.55 мянган төгрөгөөр нэмэгдсэнээр цэвэр орлого 1,652,484.29 мянган төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 48.3 хувь буюу 1,544,293.13 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 25: ХЗХ-дын ашигт ажиллагаа /мянган төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2022 оны I улирал	2023 оны I улирал
Нийт орлого	16,306,590.35	15,748,355.78
Нийт зардал	13,109,812.93	14,095,871.48
<b>Нийт орлогод зардлын эзлэх хувь</b>	<b>80.4%</b>	<b>89.5%</b>
Цэвэр орлого	3,196,777.42	1,652,484.29
<b>Нийт орлогод цэвэр орлогын эзлэх хувь</b>	<b>19.6%</b>	<b>10.5%</b>


2023 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт орлогод эзлэх зардлын хувь хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.1 пунктээр нэмэгдэж цэвэр орлогын эзлэх хувь буурсан байна.

График 11: ХЗХ-дын ашигт ажиллагаа /хувиар/



ХЗХ-ны зах зээлийн нийт орлого 2019-2022 оны 1 дүгээр улирлын байдлаар өсөлттэй байсан боловч 2023 оны 1 дүгээр улиралд буурсан үзүүлэлттэй байна.

График 12: ХЗХ-дын ашигт ажиллагаа /тэрбум төгрөгөөр/



## ЗУРГАА. ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ХЗХ-дын 2023 оны 1 дүгээр улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлээр Хорооны 2018 оны 246 дугаар тогтоолоор баталсан “Хадгаламж, зээлийн хоршооны 6.1 ХЗХ-дын шалгуур үзүүлэлтийн талаар

үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт”-ийг тооцоход дараах байдалтай байна.

Хүснэгт 26: ХЗХ-дын шалгуур үзүүлэлт хангасан байдал

№	ҮЗҮҮЛЭЛТ	БАЙВАЛ ЗОХИХ	Хангаагүй ХЗХ-дын тоо	Хувь
<b>Хөрөнгийн чанар болон хамгаалалтын үзүүлэлт</b>				
1	Хөрөнгө /актив/-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ (+ илүү, -дутуу)	107,543.00 мян.төг (32 ХЗХ) -328,844.23 мян.төг (12 ХЗХ)	44	23.0%
2	Чанаргүй зээлийн зохистой харьцаа	5%-аас хэтрэхгүй	19	9.9%
3	Нэг гишүүнд олгосон зээлийн зохистой харьцаа	30%-аас хэтрэхгүй	13	6.8%
4	Нэгдмэл сонирхолтой этгээдэд олгосон зээлийн зохистой харьцаа	30%-аас хэтрэхгүй	2	1.0%
<b>Үр ашигтай санхүүгийн бүтцийн үзүүлэлт</b>				

5	Нийт хөрөнгө /актив/-д эзлэх зээлийн зохистой харьцаа	60%-85%	82	42.9%
6	Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	10%-аас хэтрэхгүй	7	3.7%
7	Гишүүдийн хадгаламжийн зохистой харьцаа	20%-80%	22	11.5%
8	Бусдаас авсан зээлийн зохистой харьцаа	20%-аас хэтрэхгүй	23	12.0%
9	Нэг гишүүний оруулж болох хувь хөрөнгийн зохистой харьцаа	10%-аас хэтрэхгүй	2	1.0%
10	Хоршоологчдын өмчийн зохистой харьцаа	5%-аас доошгүй	30	15.7%
11	Нөөцийн сангийн байвал зохих доод хэмжээ	-	31	16.2%
12	Хадгаламж хамгаалалтын сангийн байвал зохих доод хэмжээ	-	11	5.8%
13	Тогтворжилтын сангийн байвал зохих доод хэмжээ	-	12	6.3%
<b>Зардлын зохистой хэмжээ</b>				
14	Үйл ажиллагааны зардлын зохистой харьцаа	15%-аас хэтрэхгүй	4	2.1%
<b>Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар</b>				
15	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа	4%-аас доошгүй	45	23.6%
<b>Өгөөж, зардлын хувь хэмжээ</b>				
16	Хөрөнгө /актив/-ийн өгөөж			0.6%

2023 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт ХЗХ-дын 16.8 хувь буюу 32 ХЗХ зээлийн эрсдэлийн санг 107,543.00 мянган төгрөгөөр илүү байгуулсан бол нийт ХЗХ-дын 6.3 хувь буюу 12 ХЗХ зээлийн эрсдэлийн санг 328,844.23 мянган төгрөгөөр дутуу байгуулсан байна. Нийт ХЗХ-дын 9.9 хувь буюу 19 ХЗХ чанаргүй зээлийн зохистой харьцаа, 42.9 хувь буюу 82 ХЗХ нийт хөрөнгөд эзлэх зээлийн зохистой харьцаа, 11.5 хувь буюу 22 ХЗХ гишүүдийн хадгаламжийн зохистой харьцаа, 12.0 хувь буюу 23 ХЗХ бусдаас авсан зээлийн зохистой харьцаа, 15.7 хувь буюу 30 ХЗХ хоршоологчдын өмчийн зохистой харьцаа, 2.1 хувь буюу 4 ХЗХ үйл ажиллагааны зардлын зохистой харьцаа, 23.6 хувь буюу 45 ХЗХ төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааг тус тус хангаж ажиллаагүй байна.

ХЗХ-ны зах зээлийн хөрөнгийн өгөөж 0.6 хувь байна.

Тайлант улиралд ХЗХ-дын 28.3 хувь буюу 54 ХЗХ зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажилласан бол 8.4 хувь буюу 16 ХЗХ 5 болон түүнээс дээш зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж ажиллаагүй байна.

*Хүснэгт 27: Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд*

№	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт	ХЗХ-дын тоо	Хувь
1	Шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан	54	28.3%
2	1 ЗХШҮ хангаагүй	57	29.8%
3	2 ЗХШҮ хангаагүй	40	20.9%
4	3 ЗХШҮ хангаагүй	16	8.4%
5	4 ЗХШҮ хангаагүй	8	4.2%
6	5 ЗХШҮ хангаагүй	16	8.4%
<b>Нийт дүн</b>		<b>191</b>	<b>100.0%</b>

## ДОЛОО. ДҮГНЭЛТ

Санхүүгийн тайлангийн нэгтгэлд нийт 191 ХЗХ хамрагдсанаас 6 ХЗХ-ны мэдээллийг өмнөх улирлын тайлангаар нэгтгэсэн болно.

- ХЗХ-дын статистик үзүүлэлт

2023 оны 1 дүгээр улирлын байдлаар 191 ХЗХ 61 салбар, 685 ажилтан, 69,962 гишүүн /69,721 иргэн, 241 хуулийн этгээд/-тэйгээр Монгол Улсын 21 аймаг, Улаанбаатар хотын 8 дүүрэгт үйл ажиллагаа явуулсан байна.

Нийт 191 ХЗХ-ны 25.7 хувь буюу 49 ХЗХ /төсөлд хамрагдсан 5 ХЗХ, төслийн хүрээнд байгуулагдсан 44 ХЗХ/ төсөл, хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх зөвшөөрлийн хүрээнд “Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр”-т хамрагдсан Улаанбаатар хотын ХЗХ-д байна. “Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн

хөтөлбөр”-ийн хүрээнд байгуулагдсан 44 ХЗХ-ны 34.1 хувь буюу 15 ХЗХ, төсөлд хамрагдсан 5 ХЗХ-ны 60.0 хувь буюу 3 ХЗХ төслийн зээлийн үлдэгдлийг бүрэн төлж дууссан байна.

Улсын Их Хурлаас 2022.06.17-ны өдөр Зөвшөөрлийн тухай хуулийг баталж, 2023.01.01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх болсонтой холбогдуулан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлага”-ыг тус хуульд нийцүүлэн Хорооны 2022.12.09-ний өдрийн 687 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан. Үүнтэй холбогдуулан Хорооны 2022 оны 723 дугаар тогтоолоор нэр бүхий 54 ХЗХ-ны, Хорооны даргын 2022 оны 543 дугаар тушаалаар нэр бүхий 9 ХЗХ-ны санхүүгийн бусад ажил, үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгох тухай асуудлыг шийдвэрлэсэн тул 2023.01.01-ний өдрөөс ХЗХ-д зөвхөн хадгаламж болон зээлийн үйл ажиллагааг эрхэлж байна.

Тайлант хугацаанд ХЗХ-дын нийт гишүүдийн тоо өмнөх оны мөн үеэс 6.7 хувь буюу 5,004 гишүүнээр буурч 69,962 гишүүнтэй болсон байна. Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүдийн тоо 38,326 буюу нийт гишүүдийн 54.8 хувь, орон нутгийн ХЗХ-дын гишүүдийн тоо 31,636 буюу нийт гишүүдийн 45.2 хувийг эзэлж байна.

Нийт ХЗХ-дын 51.8 хувь буюу 99 ХЗХ санхүүгийн програм хангамжтай бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1 ХЗХ буюу 1.0 хувиар буурсан байна.

Тайлант улиралд ХЗХ-дын 7.9 хувь буюу 15 ХЗХ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7.1-д заасны дагуу Монголбанкны СМА-нд 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний нийт 14,988,367.20 мянган төгрөгийн 101 гүйлгээг мэдээлсэн байна. Дээрх гүйлгээний дүнгийн 24.0 хувь буюу 3,594,836.99 мянган төгрөгийн 52 гүйлгээг

Улаанбаатар хотын 11 ХЗХ, 76.0 хувь буюу 11,393,530.21 мянган төгрөг бүхий 49 гүйлгээг орон нутгийн 4 ХЗХ мэдээлсэн байна. Тайлант улирлын байдлаар сэжигтэй гүйлгээ гараагүй байна.

- Зах зээлийн санхүүгийн үзүүлэлт  
ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгө 274,547,935.26 мянган төгрөг нь банкны зах зээлийн 0.6 хувь, нийт зээл 212,482,939.37 мянган төгрөг нь банкны зах зээлийн 0.9 хувь, чанаргүй зээл 7,516,805.43 мянган төгрөг нь банкны зах зээлийн 0.3 хувь, нийт татан төвлөрүүлсэн хадгаламж 191,450,152.31 мянган төгрөг нь банкны зах зээлийн 1.1 хувийг тус тус эзэлж байна.

ХЗХ-дын гишүүдийн нийт хувь нийлүүлсэн хөрөнгө 26,570,075.81 мянган төгрөг нь зах зээлийн нийт хөрөнгийн 9.7 хувь, хоршоологчдын өмч 32,601,894.64 мянган төгрөг нь зах зээлийн нийт хөрөнгийн 11.9 хувийг тус тус эзэлж байна.

Тайлант хугацаанд зах зээлийн хэмжээнд 15,748,355.78 мянган төгрөгийн орлого, 14,095,871.48 мянган төгрөгийн зардал, 1,652,484.29 мянган төгрөгийн цэвэр орлоготой ажилласан байна. Цэвэр орлогын хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 48.3 хувь буюу 1,544,293.13 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

2023 оны 1 дүгээр улирлыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт хөрөнгө 5.7 хувь буюу 16,744,737.09 мянган төгрөгөөр, нийт хадгаламжийн хэмжээ 5.3 хувь буюу 10,659,995.94 мянган төгрөгөөр, нийт зээлийн үлдэгдэл 3.1 хувь буюу 6,804,007.37 мянган төгрөгөөр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

- Орлого, зарлага  
Тайлант хугацаанд ХЗХ-ны зах зээлийн нийт орлогын 92.7 хувь буюу 14,602,092.40 мянган төгрөгийг хүүгийн орлого, 1.4 хувь буюу 216,620.10 мянган төгрөгийг үйл ажиллагааны бусад орлого, 5.9 хувь буюу

929,643.28 мянган төгрөгийг үйл ажиллагааны бус орлого, нийт зардлын 60.5 хувь буюу 8,525,195.47 мянган төгрөгийг хүүгийн зардал, 28.8 хувь буюу 4,052,344.35 мянган төгрөгийг үйл ажиллагааны зардал тус тус бүрдүүлж байна. ХЗХ-ны зах зээлийн хэмжээнд цэвэр орлого 1,652,484.29 мянган төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 48.3 хувь буюу 1,544,293.13 мянган төгрөгөөр буурсан бөгөөд ХЗХ-дын 20.9 хувь буюу 40 ХЗХ 985,209.78 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

- Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Тайлант хугацаанд зах зээлийн хэмжээнд Хорооноос тогтоосон зайлшгүй хангах зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг ХЗХ-дын 28.3 хувь буюу 54 ХЗХ бүрэн хангаж ажилласан бөгөөд нийт ХЗХ-дын 9.9 хувь буюу 19 ХЗХ чанаргүй зээлийн зохистой харьцаа, 42.9 хувь буюу 82 ХЗХ нийт хөрөнгөд эзлэх зээлийн зохистой харьцаа, 11.5 хувь буюу 22 ХЗХ гишүүдийн хадгаламжийн зохистой харьцаа, 12.0 хувь буюу 23 ХЗХ бусдаас авсан зээлийн зохистой харьцаа, 15.7 хувь буюу 30 ХЗХ хоршоологчдын өмчийн зохистой харьцаа, 2.1 хувь буюу 4 ХЗХ үйл ажиллагааны зардлын зохистой харьцаа, 23.6 хувь буюу 45 ХЗХ төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааг тус тус хангаж ажиллаагүй байна.

ХЗХ-ны зах зээлийн хөрөнгийн өгөөж 0.6 хувь байна.

- Хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн биелэлт

2022 оны 4 дүгээр улирлын байдлаар тусгай зөвшөөрөлтэй 196 ХЗХ-оос тайлант улирлын байдлаар нэр бүхий 6 ХЗХ-ны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, 2023 оны 1 дүгээр улиралд 1 ХЗХ-нд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг

шинээр олгосон. 2023 онд аудитын тайланг баталгаажуулж ирүүлбэл зохих 190 ХЗХ-ны 58.9 хувь буюу 112 ХЗХ жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлгэн Хороонд ирүүлсэн. Харин Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд заасны дагуу бүх гишүүдийн хурлыг зарлан хуралдуулж, бүх гишүүдийн хурлын материалыг ирүүлбэл зохих 190 ХЗХ-ны 65.3 хувь буюу 124 ХЗХ холбогдох материалыг Хороонд ирүүлсэн байна.

2023 оны 1 дүгээр улиралд нийт ХЗХ-дын 7.9 хувь буюу 15 ХЗХ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7.1-д заасны дагуу Монголбанкны СМА-нд 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний нийт 14,988,367.20 мянган төгрөгийн 101 гүйлгээг мэдээлсэн байна.

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу Улаанбаатар хотын ХЗХ-дын 52.5 хувь буюу 53 ХЗХ, орон нутгийн ХЗХ-дын 47.8 хувь буюу 43 ХЗХ Монголбанкнаас ЗМС-ийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгосон “Титан Си Ар Эй ЗМС” ХХК болон “Бүрэн скор ЗМС” ХХК-тай мэдээлэл өгөх, авах гэрээг тус тус байгуулсан байна.